ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН 2019 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2019.12.15

Нэг. Удирдлага зохион байгуулалтын талаар

Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны “Хөгжлийн хөтөч”хөтөлбөр, аймгийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан салбарын зорилтуудыг орон нутагтаа хангуулах, ХХАА-н төсвийн Ерөнхийлөн захирагч болон аймгийн Засаг даргын хооронд хамтран ажиллах 2019 оны гэрээ, ХХААХҮ-ийн Сайд, ХХААГ-ын даргын хооронд байгуулсан 2019 оны үр дүнгийн гэрээнд тусгагдсан зорилт үйл ажиллагааг хэрэгжүүлэх, зөвхөн улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд бус орон нутгийн оролцоог нэмэгдүүлэх арга хэмжээг төлөвлөн, аймгийн хэмжээнд салбарын үйлдвэрлэл, үйлчилгээ, технологийн ажлыг удирдан зохион байгуулах, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээг өсгөх, хангамж чанарыг сайжруулахад гол анхаарлаа чиглүүлж ажиллаж байна.

Аймгийн Засаг дарга, ХХААГ-ын даргатай байгуулсан үр дүнгийн гэрээнд нийлүүлбэл зохих нийт 65 арга хэмжээ бүтээгдэхүүн, тусгай захиалгат 14 бүтээгдэхүүн, төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны манлайллын зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 5 зорилт дэвшүүлж ажилласныг бүтээгдэхүүн тус бүрийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийг тооцож, үнэлж дүгнэв

Хоёр. Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах чиглэлээр

Тус газрын бүтэц 21 орон тоогоор батлагдаж, одоогоор нийт 18 ажилтан албан хаагч ажиллаж байна. Үүнээс төрийн захиргааны албан хаагч 10, төрийн үйлчилгээний албан хаагч 8 байгаа бөгөөд нийт албан хаагчдын 88% нь 5-28 жил тогтвор сууршилтай ажиллаж байна. Шинээр албан хаагч томилогдоогүй. Ажлын байрны сул орон тоо ТЗ-ны 2 буюу /Захиргаа аж ахуйн албаны дарга, газар тариалангийн үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтэн/ ТҮ-1 буюу техник хэрэгсэл программ хангамж сүлжээ аюулгүй байдал хариуцсан мэргэжилтний сул ажлын байрны захиалга, ажлын байрны тодорхойлолтыг Булган аймаг дахь төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлсэн.

2019 онд Авилгын эсрэг хууль тогтоомж, Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр зохион байгуулах 11 зорилт 23 арга хэмээний төлөвлөгөө гаргаж 95.0 хувь хэрэгжүүлж байна.

Төрийн албаны тухай хууль, түүний журмууд, Засгийн газрын 258 дугаар тогтоол зэргийг хэрэгжүүлэх хүрээнд Байгууллагын Хөдөлмөрийн дотоод журам, томилолтоор ажиллах журмуудыг шинэчлэн баталж, мөрдөн ажиллаа.

Төрийн албаны зарчим, ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлж, ажлын байранд ажил хэрэгч уур амьсгалыг бүрдүүлэх, үйлчилгээний чанарыг сайжруулах, соёлтой, ил тод чирэгдэлгүй хүргэх зорилгоор Засгийн газрын 33 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэмтэй уялдуулан Байгууллагын үйлчилгээний стандартыг Газрын даргын 2019 оны А/11 дугаар тушаалаар шинэчлэн баталсан.

Ажилчин албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх төлөвлөгөөг батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж, гадаадад 3, улс, аймаг, орон нутагт зохион байгуулсан сургалтуудад давхардсан тоогоор 13 албан хаагч сургалтанд хамрагдаж, мэргэжлийн ур чадвараа нэмэгдүүлсэн.

2019 онд сумдын ХАА-н тасгийн 43 мэргэжилтэнд 3 удаагийн сургалт, цахим сургалтыг 1 удаа зохион байгуулж, салбарын хууль, тогтоол, төсөл, хөтөлбөрийн талаар мэдээлэл өгч мэргэжил арга зүйгээр ханган гарын авлага материал өгч ажиллаа.

Байгууллагын гадаад үзэмж, чанарыг сайжруулах зорилгоор 26 800 000 төгрөг, шугам халаалтыг нэмэгдүүлэх засварын ажил гүйцэтгүүлэхэд 6 200 000 төгрөгийн санхүүжилтүүд шийдвэрлүүлэн гүйцэтгүүлсэн. Албан хаагчдын техник тоног төхөөрөмж, тавилга хэрэгслийн судалгааг авч, хангах, сайжруулах арга хэмжээний хүрээнд 10 000 000 төгрөгний хөрөнгө оруулалтаар худалдан авах ажлыг хийсэн.

Үүссэн өр авлагагүй, санхүүгийн сахилга баттай, санхүүгийн тайлан мэдээг хуулийн хугацаанд өгч ажилласан.

Хоёр. Боловсруулсан асуудал

Аймгийн ИТХ-ийн хурлаар 1, ИТХТ-ийн хуралдаанаар 10, Засаг даргын зөвлөлийн хурлаар 17, газрын удирдлагын зөвлөлийн хурлаар 23 асуудал хэлэлцэж, шийдвэрлэсэн. Үүнд: “Шинэ хөдөө булган” дэд хөтөлбөр, “Зөгий” дэд хөтөлбөр, бусад дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх жилийн ажлын төлөвлөгөө, 2019-2020 онд Мал аж ахуйн өвөлжилтийн бэлтгэх хангах төлөвлөгөө, бэлтгэл хангасан дүн, улс, аймгийн аварга малчин, тариаланч, тариаланч хамт олон шалгаруулах асуудал, зохион байгуулах арга хэмжээний төслүүдийг боловсруулан хэлэлцүүлсэн.

Гурав. Зөвлөгөөн, сургалт зохион байгуулсан арга хэмжээ

Монгол улсад “Атар газар эзэмшсний 60 жил”-ийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх төлөвлөгөө гарган аймгийн газар тариалангийн салбарын түүхэн хөгжлийг баяжуулах ахмад болон залуу тариаланчдын хөдөлмөрийн амжилтыг сурталчлах зорилгоор баримтат кино хийх, тариаланчдын дуу хийх, түүх бичих ажлуудыг хийж, тариаланчдыг шагнаж урамшуулж ойн арга хэмжээ, "Малын чанарыг сайжруулж, бэлчээрээ хайрлая" уриан дор малчдын зөвлөгөөнийг зохион байгуулж, малчдад хандсан зөвлөмж гаргаж, Орон нутгийн

үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдийн бүтээгдэхүүн үйлчилгээний борлуулалтыг дэмжиж, “Намрын ногоон өдрүүд-Булганд үйлдвэрлэв”, “Цагаан сар-Булган түншлэл” үзэсгэлэн худалдаануудыг зохион байгуулж, шилдэг үйлдвэрлэгчдээ шагнаж урамшуулж, Орон нутгийн төдийгүй үндэсний брэнд уламжлалт исэг цагаан идээ айрагны соёл, ёс заншил, тогтоом наадгай, зан үйлийг сурталчлах зорилгоор “Айрагны баяр”-ыг анх удаа нийслэл Улаанбаатар хотод зохион байгуулж, нийт 1500 гаруй хүн оролцсон.

Төрийн болон төрийн бус байгуулагатай хамтран 49 удаа сургалт зохион байгуулж, 16 сум 1 тосгоны 4000 гаруй иргэд, малчин, тариаланчдад салбарын хууль, тогтоомж, үйл ажиллагааг сурталчлан таниулж, зөвлөн туслах ажлыг зохион байгуулсан. Мөн 6000 гаруй ш гарын авлага материалаар хангаж ажиллаа. Үүнд:

<u>Гурав. Мэдээлэл, сурталчилгааны чиглэлээр</u>

“Булганы мэдээ” сонин”, “Сайхан монгол” телевизтэй хамтран жил бүр хамтран ажиллаж байгууллагаас зохион байгуулж буй үйл ажиллагаа болон цаг үеийн мэдээллийг сонинд хэвлүүлж иргэдэд мэдээлэл хүргэж байна. “Иргэдээ сонсъё” орон нутгийн нэвтүүлгийг 2 удаа оролцож, салбараас зохион байгуулж буй үйл ажиллагаа цаашид авах арга хэмжээ, иргэдийн санал хүсэлтийн дагуу хариулт, мэдээлэл өгсөн.

“Нээлттэй хаалганы өдөр”-ийг 10,11 дүгээр сард зохион байгуулж, Засаг даргын “Хөгжлийн хөтөч” хөтөлбөрт тусгагдсан салбарын 7 зорилт 80 арга хэмжээний хэрэгжилтийг ажлын хэсэгтэй хамтран 76 багийн иргэдэд танилцуулж, ажилласан. Мөн аймгийн төвийн 6 багт салбарын хууль тогтоомж, сурталчлах ажлыг төрийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж, салбарын үйл ажиллагааны талаар саналын хуудсаар 120 санал авч, иргэдэд зөвлөгөө заавар өгч, 350ш гарын авлага бэлтгэн тараасан.

“Атар 60 жил” баримтат кино, Булган аймгийн газар тариалан 60 жилд ном, “Булганы буудай” дуу хийж нийтийн хүртээл болголоо.

Аймгийн ЗДТГ-тай хамтран “Шинэ хөдөө-Булган” дэд хөтөлбөрийн тайлант өдөрлөгийг зохион байгуулж, 2019 онд нийлүүлэгдэж буй төмс хүнсний, ногооны дунд оврын тракторыг 6 суманд, арьс шир боловсруулах тоног төхөөрөмжийг 15 суманд, сүүний хөргүүртэй чингэлэг-6, хүлэмж - 101, өндөр ашиг шим бүхий бух, хуц, ухна зэргийг хүлээлгэн өгч, нийт 400 гаруй хүн оролцов.

Хүнс, худалдаа үйлчилгээний салбарыг хөгжүүлэхэд анхаарч “Шинэ хөдөө Булган” төсөл, “Мах, сүү аян”, “Давс багатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжье аян”, “Нэг суурин нэг бахархал аян”-уудыг дэмжин сургалт, мэдээлэл, гарын авлага боловсруулан хэвлүүлж, хэвлэл мэдээллээр 2 удаагийн ярилцлага хийн, 4 төрлийн шторкыг “Сайхан Монгол” ТВ

болон гадна талбайн дэлгэцүүдээр давталттайгаар цацаж иргэдэд сурталчилан ажилласан.

ХХААХҮС-ын 2017 оны 04 сарын 14 өдрийн А-45 тушаалаар батлагдсан “Мах, сүүний анхдугаар аян”-ыг эрчимжүүлэх хүрээнд газрын даргаар батлуулсан 27 ажил бүхий арга хэмжээг ажлын хэсгийн бүрэлдэхүүн аймгийн хэмжээнд амжилттай хэрэгжүүлсэн.

Аймгийн Засаг даргын “Иргэнд ойрхон төрийн үйлчилгээ” үйл ажиллагааг зохион байгуулах тухай” 2019 оны 04 дүгээр сарын 26-ны А/244 дүгээр захирамжийн хүрээнд МАА-н алба, МХГ-ын улсын байцаагчтай хамт батлагдсан удирамжийн дагуу 16 сум, 1 тосгоны 309 малчин өрхийн 694 малчин, 200 төлчин эмэгтэйчүүдтэй уулзаж, санал солилцон, мэдээ мэдээлэл хүргэж ажилласан.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан А-119/А/355 дугаар бүхий тушаал, ХХААХҮ-ийн сайдын 2019 оны 02 сарын 19 -ны 01/575 дугаар бүхий албан тоотыг эрчимжүүлэх хүрээнд аймгийн Засаг даргын 2019 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн А/200 тоот захирамжаар “Давс багатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжье” аяныг зохион байгуулах ажлын төлөвлөгөөний 16 сум 1 тосгоны давхардсан тоогоор сургалтыг 3000 гаруй хүнд хийж, 5000 орчим иргэдэд тараан сурталчлан ажилласан байна.

Дөрөв. Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод шалгалтын талаар

ХХААХҮ-ийн сайдын 2017 оны А-159 дугаар тушаал, Аймгийн Засаг даргын 2017 оны А-280 дугаар захирамжаар баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын дагуу жилийн эцсийн байдлаар 18 бодлогын баримт бичиг, 61 тогтоол шийдврийн хяналтанд авч, хэрэгжилтэнд хяналт шинжилгэ үнэлгээ хийж, аймгийн ЗДТГ, ХШҮДАХэлтэст хүргүүллээ.

Байгууллагын дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөг батлуулж хэрэгжилтийг 90 хувьтай хангав. Хяналт шалгалтын мөрөөр зөвлөмж гаргаж, үр дүнг сайжруулах арга хэмжээг авч ажилласан. Дотоод болон бусад хамтран ажилладаг байгуулагатай Хүнсний аюулгүй байдлыг хангах чиглэлээр 5, ЖДҮДС-ийн чиглэлээр 2 удаа, мал аж ахуйн чиглэлээр 4, газар тариалангийн чиглэлээр 4, байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд 3, нийт 18 удаа хяналт шалгалт хийж, 28 зөрчил илэрүүлж, зөвлөмж хүргүүлж ажиллаа.

Тав. Үйлдвэрлэлийн ажлын үр дүн

5.1. Мал аж ахуйн чиглэлээр:

Аймгийн дүнгээр жилд дунджаар 38.8 мянган тонн малын мах, 44.3 мянган литр сүү, 1.8-2.1 мянган тонн ноос, 250.0-277.2 тонн ноолуур, 755.6-800.0 мянган ширхэг арьс,

ширийг үйлдвэрлэж, хүн амын хүнсний хэрэгцээт мах, сүүний бэлтгэлийг 100 хувиар тус тус хангаж байна.

Аймгийн ИТХ-ын 11-р хуралдааны 03 дугаар тогтоолоор 5 жилийн хугацаанд хэрэгжүүлэхээр 6 зорилт бүхий "Шинэ хөдөө-Булган" дэд хөтөлбөрийг батлуулж, энэ онд "Шинэ хөдөө" төслийн хүрээнд улсын төсвийн 2.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 18 багц худалдан авах ажиллагааны нээлттэй тендер зарлаж, тодорхой ажлуудыг эхлүүллээ.

2019 онд мөн Сэлэнгэ суманд Герефорд үүлдрийн 15 бух, Хангал, Хутаг-Өндөр, Бугат, Тэшиг, Баян-Агт суманд "Сэлэнгэ" үхрийн 1-р үеийн эрлийз 35 бух, 16 сумын нийт 44 багт "Сэлэнгэ" үүлдрийн 44 бухыг тус тус хүлээлгэн өгч, үржилд ашиглахаар бэлтгэл хангаж байна.

"Сэлэнгэ үүлдрийн үхрийн чанарыг сайжруулж ажилласнаар 2024 он гэхэд нийт үхэр сүргийн 16.5 хувьтай тэнцэхүйц хэмжээний өндөр ашиг шимт мал бий болгох төлөвлөгөөтэй бөгөөд 1 үхрийн амьдын жин дунджаар 60-70 кг-аар нэмэгдэж, жилд нийт 42900 үхрээс 1287 тн мах буюу өнөөдрийн ханшаар тооцвол 7.7 тэрбум гаруй төгрөгийн нэмүү орлого бий болгох тооцоотой байна.

2019 онд "Цагаан уул" үүлдрийн 120 толгой төлгөн хуцыг урд бүсийн 54 малчин өрхөд үржилд ашиглуулахаар гэрээ байгуулан олголоо. "Баяд" үүлдрийн 300 хуц, "Эрчмийн хар" үүлдрийн 50 ухныг худалдан авч, хойд бүсийн сумдад нийлүүлэх ажлыг зохион байгуулж байна.

Дээрх ажлыг зохион байгуулснаар өндөр ашиг шимтэй малын нийт сүрэгт эзлэх хувь 7-8 хувиар өсч, нэгж малаас авах ашиг шимийн үзүүлэлт нэмэгдэж, хонины махан ашиг шим 2-3 кг, ноосны гарц 200-320 гр, ямааны ноолуур 100-150 гр-аар нэмэгдэхээр тооцоотой байна.

"Хангай" үүлдрийн хонийг үржүүлж Бүрэгхангай сумаас 251 толгой "Хангай" хонийг Сэлэнгэ сумын 4-р багт нүүлгэн шилжүүлж, сайжруулалт хийж ажилласнаар хонины тарга тэвээрэг, хээл авалт дээшилж, төл малын хорогдол багасч, ноосны чанар, амьдын жин нэмэгдсэн эерэг үр дүнгүүд гарч, 2019 онд ХХААХҮЯ-аас зохион байгуулсан "Шилмэл малын үзэсгэлэн худалдаа"-нд манай шилмэл "Хангай" хонь амьдын дундаж жин, ноосны чанар, гарцын үзүүлэлтээр "Алтан" медаль авлаа.

2019 онд "Булган-Зөгий" дэд хөтөлбөрийг батлуулан хэрэгжүүлснээр зөгийн аж ахуй эрхлэлт нэмэгдэж, 102 өрх зөгийн аж ахуй эрхлэж 1103 бүлээс 16.5 тн бал хураан авч, өрхийн орлогоо нэмэгдүүлсэн байна.

Булган, Хангал, Сэлэнгэ, Бугат, Тэшиг, Хутаг-Өндөр, Баян-Агт, Хялганат тосгоны нийт 43 иргэнийг зөгийн аж ахуй эрхлэлтийн чадамж олгох сургалтад хамруулж, нийт 250 бүл зөгий, дагалдах хэрэгслээр дэмжлээ.

“Шинэ хөдөө Булган” дэд хөтөлбөрийн хүрээнд хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний борлуулалтын сүлжээг бий болгох зорилгоор 15 суманд нэг ээлжиндээ 25-аас дээш арьс боловсруулах хүчин чадал бүхий арьс, нэхий элдэх иж бүрэн тоног төхөөрөмж 15 ширхэг, Хутаг-Өндөр, Сайхан, Хангал, Сэлэнгэ, Орхон, Дашинчилэн, Бугат сум тус бүрт 20 тн-ын чингэлэгт суурилагдсан 3 тн сүү агуулах хүчин чадалтай шинжилгээний багаж бүхий сүүний хөргөлтийн танк, Сайхан суманд айраг хадгалах 40 тн-ын хөргүүрт чингэлгийг хүлээлгэн өглөө.

Аймгийн хэмжээнд малчдын зөвлөгөөнийг жил бүр уламжлал болгон зохион байгуулж байгаа бөгөөд 2019 оны зөвлөгөөнийг 16 сумын 387 малчдын төлөөллийг оролцуулсан "Малын чанарыг сайжруулж, бэлчээрээ хайрлая" уриан дор зохион байгуулж, малчдад хандсан зөвлөмж гарган, хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулж байна.

Швейцарийн хөгжлийн агентлагийн санхүүжилтээр хэрэгжиж байгаа “Ногоон алт-Малын эрүүл мэнд” төслийн хүрээнд Дашинчилэн, Могод, Хишиг-Өндөр, Орхон, Сайхан сумдад бэлчээрийг зүй зохистой ашиглах, малчдын дунд бэлчээр ашиглагчдын хэсэг байгуулах, малчдын дундын сангийн хуримтлал бий болгох чиглэлээр 2-3 удаагийн сургалт зохион байгууллаа. Үүний дүнд аймгийн хэмжээнд бэлчээр ашиглагчдын 24 хэсэг байгуулагдан, үйл ажиллагаа явуулж байна.

ХХААХҮ-ийн сайдын 2019 оны А-303 дугаар тушаал, ХХААХҮ-ийн сайдын 2019 оны А-86 дугаар тушаал, Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны А/118 дугаар тушаалаар тус аймгийн бэлчээрийн 90.8 мянган га талбайд үлийн цагаан оготнотой тэмцэх арга хэмжээг хавар намрын улиралд хэрэгжүүлж, Гурванбулаг, Могод, Хишиг-Өндөр Сайхан, Дашинчилэн, Рашаант сумдад энгийн механик, биологийн аргаар тэмцэх ажлыг зохион байгуулж, тухайн сумдын ЗДТГ орон нутагтаа хэрэгжүүлэх үүрэгтэй ажиллав. Аймгийн төвшинд 82.0-83.0 % буюу Сайн хэрэгжүүлсэн үр дүнтэй байна.

Аймгийн хэмжээнд инженерийн хийцтэй болон энгийн 983 худаг ашиглахад бэлэн байгаа бөгөөд Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Дашинчилэн, Баяннуур, Рашаант, Гуванбулаг, Могод, Сайхан, Баян-агт, Тэшиг, Бугат 12 худаг шинээр гаргаж, хүлээлгэн өгсөн. Үүний үр дүнд 5.0 мянган га талбайг усжуулж, 40 гаруй мянган толгой мал усаар хангагдах нөхцөл бүрдлээ. Улсын төсвөөс 187.0 сая төгрөг зарцуулсан.

Малын генетик нөөцийн тухай хууль, Засгийн газрын 2016 -2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, “Монгол мал” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны “Гэрээ байгуулах эрх олгох тухай” А/207 дугаар тушаалыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн Засаг даргын 2019 оны Малын ялган тэмдэглэж, бүртгэлжүүлэх ажлыг зохион байгуулах тухай А/458 дугаар захихамж, ХХААГ-ын даргын 2019 оны “Гэрээ байгуулах эрх олгох тухай” А/16 дугаар тушаалын дагуу үржлийн аж ахуйн нэгж “Хужирын адаг”ХХК, “Ингэт

сүрэг” ХХК-иудтай гэрээ байгуулан аймгийн хэмжээнд 2354 толгой бух, 7987 толгой хуц, 4569 толгой ухна, 1140 толгой эм хонь нийт 16050 толгой үржлийн малыг ялган тэмдэглэж бүртгэлжүүлэх ажлыг зохион байгуулсан.

2019 оны ноосны урамшуулалд нийт 4109 малчин өрхийн 830.5 мянган тн хонь, 470 кг тэмээний ноосыг үндэсний үйлдвэрт тушааж 829.3 сая төгрөгийг ХААН болон Төрийн банкаар малчдын дансанд шилжүүлэн олгосон.

5.2.Газар тариалангийн чиглэлээр:

Газар тариалангийн үйлдвэрлэлд дэвшилтэт шинэ техник, технологи нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлж, усалгаатай талбайг нэмэгдүүлэн, эргэлтийн талбайн ашиглалтыг сайжруулах, тогтвортой ажлын байр бий болгох зорилтын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Монгол улсад атар газар эзэмшсний 60 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх төлөвлөгөө гарган аймгийн газар тариалангийн салбарын түүхэн хөгжлийг баяжуулах ахмад болон залуу тариаланчдын хөдөлмөрийн амжилтыг сурталчлах зорилгоор баримтат кино хийх, тариаланчдын дуу хийх, түүх бичих, тариаланчдыг шагналд тодорхойлох зэрэг төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг хэрэгжүүлсэн. Ойн арга хэмжээг 11- р сарын 27-28-ны өдрүүдэд тэмдэглэн өнгөрүүлж, газар тариалангийн үйлдвэрлэлийн үе үеийн ахмадуудын төлөөлөл 450-аад хүн оролцсон. Ойн арга хэмжээний хүрээнд тариаланчдыг алдар гавъяаг нь урамшуулж, төрийн дээд одон медаль, ойн медаль, аймгийн шагналаар урамшуулж, газар тариалангийн үйлдвэрлэгч аж ахуйн нэгж, иргэнийг шилдэг 9 номинацаар шалгаруулсан.

Аймгийн тариаланчдын зөвлөгөөнийг “Атрын гурав дахь аян”-ы хүрээнд зохион байгуулж, Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн, "Каритас монгол" ТББ, "B&T Analysis" ХХК-тай хамтран газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч 208 хүнд "Уртасгасан хугацаатай хүлэмж барих аргачлал, загварууд" сэдвээр сургалт зохион байгууллаа.

2019 оны хаврын тариалалтаар нийт 49619 га-д тариалалт хийснээс үр тариа 42960 га-д, үүнээс улаанбуудай 39464 га, бусад үр тариа 1034 га, ногоон тэжээл 1183 га-д, тосны ургамал 7466 га-д, төмс 353 га-д, хүнсний ногоо 118.7 га-д тариалсан. Ургац хураалтын мэдээгээр үр тариа нэгжээс 13.7 цн буюу 53.050 тн, буудай 13.8 цн буюу 52046 тн, бусад үр тариа 1003, тн, малын тэжээл 5618.5 тн, тосны ургамал 2361 тн, төмс нэгжээс 116,4 цн буюу 4113.1 тн, хүнсний ногоо 73 цн буюу 872.4 тн жимс жимсгэнэ 28.5 тн хураан авч 42000 га-д химийн болон механик хосолсон уринш бэлтгэсэн.

Хураан авсан ургацаар тооцоход аймгийн хүн амын гурил, төмсний хэрэгцээ 100 хувь, хүнсний ногооны хэрэгцээ 18.6 хувиар хангагдаж, нэгжийн ургацын дүнгээр улсын дунджаас

үр тариа 1.3 цн-ээр илүү, төмс, хүнсний ногооны ургац өмнөх оноос 1243 тн-оор нэмэгдсэн нь ганд тэсвэртэй сортын үрээр тариалалт хийх бодлого барьж ажилласан, газар тариалангийн үйлдвэрлэлд цаг агаарын таатай нөхцөл бүрдсэн зэрэгтэй холбоотой гэж дүгнэж байна.

Үүний зэрэгцээ Хятад сортын үр бүрэн халагдсан бөгөөд хүнсний ногооны тариалалтанд бөөрөнхий сонгины эзлэх хувь 15%-иар цагаан болон улаан хальстай сармисыг үржүүлэх, тариалах ажил нэмэгдэж тарих үр болон бэлтгэсэн уриншийн чанар сайжирч, дэвшилтэт технологид нийцсэн техникийн хангамж, үр тарианы үйлдвэрлэл 40-50 хувьд хүрч, тариалалт уринш, ургац хураалтыг 14-20 хоногт гүйцэтгэх хүчин чадалтай болсон эерэг үр дүнгүүд гарсан.

“Жимс, жимсгэнэ” үндэсний хөтөлбөрийн хүрээнд чацаргана болон бусад жимс жимсгэнэ тариалах хөдөлгөөн өрнүүлэн, 1693 иргэн, 132 бүл, 898 өрхийг хамруулж, дэмжлэг үзүүлсний үр дүнд аймгийн жимс жимсгэнийн талбай 715 га-д хүрч, үүний 98.3 хувийг чацаргана эзэлж байна.

“Шинэ хөдөө” төслийн 500.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 9 суманд нарны эрчим хүчээр ажиллах ус өргүүр бүхий инженерийн хийцтэй худаг гаргаж, Дашинчилэн, Баяннуур, Бүрэгхангай, Бугат, Хутаг-Өндөр сумдад тус бүр нь 10 га талбайг услах хүчин чадалтай 8 иж бүрдэл дуслын усалгааны систем, Сэлэнгэ, Бүрэгхангай, Булган, Рашаант, Орхон, Тэшиг сумдад төмс, хүнсний ногооны манагч, бууц цацагч, үрлэгч, хураагч 6 ширхэгийг, бүх сумуудад 4*8 хэмжээтэй 101 ширхэг нийлэг хальсан хүлэмжийг усалгааны тоног төхөөрөмжийн хамт хүлээлгэн өглөө.

Энгийн усалгаагаар энэ жил 1200 га талбайд төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалж байна. Дуслын усалгаа, хөрсөн доороос нэвчүүлэх усалгаа нь хамгаалалттай хөрсөнд хэрэглэгдэж байна. Одоогоор 99 ширхэг 8944м2 зуны хүлэмж, Хангал сумын “Эко хан” буян хоршоо өөрсдийн хөрөнгөөр барьсан 800 м2 өвлийн хүлэмжинд эдгээр усалгааны аргыг хэрэглэж байна.

Булган сумын 1-р баг Байшинтын 20 га чацарганын талбайд 0,4 кВ-ын шугамыг 23.9 сая төгрөгөөр, Майдарын 10 га чацарганын талбайд 0,4 кВ-ын шугамыг 29,5 сая төгрөг, Рашаант сумын 10 га чацарганын талбайд 10 кВ-ын шугам, 10/0,4 кВа-ын иж бүрэн дэд станц барих ажлыг 21,4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар тус тус гүйцэтгэлээ.

ОХУ-ын Красноярск хотын ХАА-н Их сургуультай хамтран ажиллах гэрээний дагуу Сэлэнгэ сумын “Ингэттолгой” ХК, Тэшиг сумын “Шинэ амжилт” ХХК-ууд 3 бүсэд Сибирийн 3 сортын улаан буудайг турших тариалалтыг дахин хийсэн.

Ганд тэсвэртэй, нутагшсан сортын үрийн нөөцийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд Бүрэгхангай сумын “Төлүүжин” ХХК, Сэлэнгэ сумын “Ингэттолгой” ХК, Хутаг-Өндөр сумын “Улаан буудайн эх газар” ХХК-иуд Дархан-Уул аймгийн Ургамал Газар Тариалангийн

Хүрээлэнтэй хамтран, эх орны 5 сортыг нутагшуулан үржүүлж байгаа бөгөөд нийт тариалж буй үрийн 70 хувийг нутагшсан сортын үрээр тариалж байна.

Үр тарианы үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгж, иргэд өөрсдийн санхүүгийн боломжоор техникийн шинэчлэлийг хийж байна. Газар тариалангийн эргэлтийн талбайг өндөр хүчин чадлын техникийн нормтой харьцуулсан судалгаагаар ашиглаж байгаа нийт техникийн гүйцэтгэх ажлын 70-80 хувь нь орчин үеийн шаардлага хангасан техникээр хийгдэж байна.

Үр тарианы үйлдвэрлэлийн парк шинэчлэл хийгдэж байгаа, харин төмс хүнсний ногооны үйлдвэрлэлийг механикжуулах талаар сумдын Засаг дарга нарын гэрээнд жил бүр тусгаж өгдөг ч ахиц гарахгүй байна.

УГТХ-ээс Хутаг-Өндөр сумын "Улаан буудайн Эх газар" ХХК, Бүрэгхангай сумын Төлүүжин ХХК-тай хамтран нутагшсан сортын үр үржүүлэхээр тариалж үрээ хураан авч нөөцлөөд байна.

Засгийн газрын 131-р тогтоолоор Хутаг-Өндөр сумын 1,2,5-р багийн тариалангийн талбай бүхий газар нутгийг тариалангийн бүс нутгаар тогтоож 100 км хашаа барих ажлыг "Наму дэвжих" ХХК барьж орон нутгийн өмчид бүртгүүлээд байна.

5.3.Үйлдвэрлэл, үйлчилгээ, жижиг, дунд үйлдвэрлэлийн чиглэлээр:

2019 онд нийтийн хоол үйлдвэрлэлийн 143 цэг, төрийн байгууллагын хоол үйлдвэрлэл буюу сургууль, цэцэрлэг, эмнэлэг, албан байгууллагын харьяа хоол үйлдвэрлэл 165, хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч 59, хүнсний худалдаа эрхлэгч 267, эрчимжсэн аж ахуй эрхлэгч 35, хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч мал бүхий обьект 9, хүнсний худалдаа, малын гаралтай бүтээгдэхүүн борлуулагч, хадгалагч, тээвэрлэгч 43, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх 64, мал үржлийн үйлчилгээ үзүүлэгч 3, малын эм, эмнэлгийн хэрэгсэл худалдаалагч 4 цэг бүртгэлтэй байна.

2019 онд орон нутагт малын мах бэлтгэх, боловсруулах /сумын нийт хүн амын өөрсдийн хүнсэнд хэрэглэсэн болон худалдан борлуулсан махны хэмжээ хамтдаа орсон болно./ 2369.9 тн, шувууны мах 2.1 тн, загасны мах 2.7 тн, үнээний сүү 2372.2 тн, цагаан идээ 1530.5 тн, төрөл бүрийн будаа 23304.3 тн, төмс 6540.6 тн, хүнсний ногоо 1134.3 тн, жимс, жимсгэнэ 468.7 тн, буурцагт ургамал 41.8 тн, цөцгийн тос 22.98 тн үйлдвэрлэсэн байна.

Боловсруулах үйлдвэрээс 283.9 тн мах, 151.2 тн сүү, гурил 992.9 тн, гурилан бүтээгдэхүүн 1822.2 тн, өндөг 94.38 тн үйлдвэрлэсэн байна.

Аймгийн Засаг даргын 2019 оны 04 сарын 11 өдрийн А/200 дугаар захирамжаар "Давс багатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжье" аяныг зохион байгуулах ажлын хэсэг, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлуулан ажиллаа. Аяны талаар 8 сумын 300 орчим иргэдэд танилцуулж , сургалт мэдээлэл хийж, орон нутагтаа хэрэгжүүлэн ажиллахыг

уриалан, 6 төрлийн гарын авлага материал тараасан. Аянд хүнс, хоол үйлдвэрлэгч нийт 19 аж ахуйн нэгж оролцохоор бүртгүүлж, хоолны дээжүүдийг МХГ-т хүргүүлэн 2-3 удаагийн дээжийг шинжилгээнд хамруулаа.

Хүнсний бүтээгдэхүүний хаяг шошго, үйлдвэрлэлтийн хугацааг хэрхэн харах, хүнсний зориулалтын бус хуванцар савны талаарх мэдээлэл хийж, 20 гаруй төрлийн 5000 орчим гарын авлага материал бэлтгэн тарааж, иргэдэд сурталчилан ажилласан. Булган сумын үйлдвэрлэгч "Саруул" нарийн боовны цех "Давс багатай гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэгч"-ээр шалгарч "Өргөмжлөл" 1.0 сая төгрөгөөр шагнуулсан

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 75 дугаар тогтоолоор Булган, Орхон сумдын хилийн зааг "Домын дэвсэг"-ийн 140.4 га газарт үйлдвэрлэлийн бүсийг төлөвлөж, Техник эдийн засгийн үндэслэл /ТЭЗҮ/ боловсруулах ажлыг судалгаа, шинжилгээний "Эс ай си эй" ХХК- аар гүйцэтгүүллээ.

Булган сумын "Билгүүн Дэлгэрэх" ХХК-ийн шахмал түлшний үйлдвэрийн тоног төхөөрөмжийн шинэчлэл хийхэд сум хөгжүүлэх сангаас 50.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлснээр жилд дунджаар 40-50 тн шахмал түлш үйлдвэрлэж, иргэдийн хэрэгцээнд нийлүүлж байна.

Бугат сумын Төлүүгийн даваа, Булган сумын 1 дүгээр багийн нутагт улсын чанартай авто зам дагуу орон нутгийн үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжих зорилгоор худалдааны цэг байгуулж, зам талбайн барилга угсралтын ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Булган сумын "Хатан Мээж хайрхан" ХХК өөрийн хөрөнгө болон ЖДҮХС-ийн хөнгөлттэй зээлийн нийт 940.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хуучин барилга обьектыг засварлан, хоногт 20 тн-ын хүчин чадалтай, технологийн уурын болон объеоктийн халаалтын систем бүхий сүүний үйлдвэр байгуулж, үйлдвэрийн тоног төхөөрөмжийг бүрэн суурилуулаад байна.

Хутаг-Өндөр сумын "Булган мах маркет" ХХК хүнсний аюулгүй байдлын "Олон улсын хяналтын тогтолцоо"-ны стандартыг нэвтрүүлэх болзол, шалгуурыг хангаад байна. Одоогоор тус аж ахуйн нэгж Иран, БНХАУ, Казакстан улсад хонь, адууны мах экспортолж эхлээд байна.

Булган суманд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар Бизнесийн жишигт нийцсэн худалдааны төв ашиглалтад орж, 50 гаруй иргэн ажлын байраар хангагдлаа.

Булган аймагт үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнийг худалдан авч, дотоодын үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих, орон нутгийн иргэдийг ажиллах хүчээр авч, ажлын байрыг нэмэгдүүлэх талаар аймгийн нийт иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, хөрөнгө оруулагчдад "Уриалга" гаргаж ажилласнаар зөвхөн аймгийн төвийн төр, төсвийн байгууллагууд орон нутгийн зах зээлээс нийт 6.2 тэрбум төгрөгийн худалдан

авалт хийж, зарим төрлийн эм эмнэлгийн хэрэгсэл, авто машины сэлбэгээс бусад хэрэгцээт бараа ажил үйлчилгээгээ орон нутгаасаа авч хэвшлээ.

Мөн түүнчлэн 2019 оныг Монгол улсын засгийн газраас “Эх оронч худалдан авалтын жил” болгон зарласантай холбогдуулан аймгийн Засаг даргын дэргэдэх төр, төсвийн байгууллагууд орон нутгийн зах зээлээс 1.7 тэрбум төгрөгийн худалдан авалт хийж бизнес эрхлэгчдээ дэмжсэн байна.

Орон нутгийн үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдийн бүтээгдэхүүн үйлчилгээний борлуулалтыг дэмжиж, “Намрын ногоон өдрүүд-Булганд үйлдвэрлэв”, “Цагаан сар-Булган түншлэл” үзэсгэлэн худалдаануудыг зохион байгуулж, шилдэг үйлдвэрлэгчдээ шагнаж урамшуулж, хэвшлээ.

5.4. Жижиг, дунд үйлдвэр, хөнгөн, хоршоо,
ахуй үйлчилгээний салбар

Аймгийн Засаг даргын захирамжаар Тусгай сангуудын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх ажлын хэсэг, Сум хөгжүүлэх санд улсын үзлэг зохион байгуулах ажлын хэсэг, “Нэг суурин-Нэг бахархал” аяныг зохион байгуулах ажлуудыг зохион байгуулсан.

Аймгийн үйлдвэрлэл үйлчилгээний бодлогын 2014-2018 оны хэрэгжилтийг Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурал, ИТХТэргүүлэгчдийн хурал, Намын бүлгүүдийн хурал, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар тус тус хэлэлцүүлсэн.

Жижиг дунд үйлдвэрийг дэмжих сангийн хүрээнд :

ХААН, ХАС, Төрийн банкуудаар дамжуулан нийт 68 төсөлд 2.9 тэрбум төгрөгийн зээл олгосоноос 57 төслийн 2.8 тэрбум төгрөг бүрэн төлөгдөж зээлийн эргэн төлөлт 96.1 хувьтай байна.

Орон нутагт жижиг, дунд үйлдвэрийг дэмжих зорилгоор жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас нэг тэрбум төгрөгийн эх үүсвэр хувиарласаны даагуу жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох төсөл сонгон шалгаруулах журам батлагдаж, нийтдээ 87 зээлдэгчийн 5.7 тэр бум төгрөгийн төсөл битүүмжлэн хүлээн авч программд ерөнхий мэдээллийг оруулсан. Журмын дагуу газрын даргын .... тушаалаар ажлын хэсэг томилж, иж бүрдэлийг шалгалтыг хийж, журмын 1.4 дэх заалтыг хангаагүй 38 төсөл хасагдаж, иж бүрдэл бүрэн 49 төсөл Дэд хорооны шатанд шилжүүлсэн.

Дэд хорооны хурал 2019 оны 07 дугаар сарын 16, 17-ны өдрүүдэд хуралдаж, 7 гишүүний онооны дүнгээр эрэмблэгдэн 1, 2 дугаар жагсаалтыг Аймгийн Засаг даргын захирамжаар баталгаажуулан зээлдэгчийн сонгосон арилжааны банкинд хүргүүлсэн.

Булган аймаг дахь ХААН банкны салбараар дамжуулан 20 төсөлд 980.0 сая төгрөгийн санхүүжилтээр арьс шир боловсруулах, мах, махан бүтээгдэхүүн, тэжээлийн үйлдвэрлэл, мод, модон бүтээгдэхүүн үйлдвэрлэл, төмс, хүнсний ногоо, Барилгын материал үйлдвэрлэлийн чиглэлээр зээл олгогодож, 10 ажлын байр шинээр, 25 ажлын байр хадгалагдан үлдсэн байна.

“Мерси-Кор” ОУБ-аас Тэшиг сумын "Мөнх түрүү" ХХК нь малын тэжээл үйлдвэрлэх цех барих, 4 төрлийн тэжээл тариалах чиглэлээр 60.0 сая төгрөгийн дэмжлэг авсан.

Сум хөгжүүлэх сангийн хүрээнд:

2019 оны 14 сум 145 төсөлд 987 046 000 төгрөгийн зээл олгож, шинэ 206, хадгалсан 181 ажлын байр бий болсон байна. Салбараар нь ангилвал: Хөнгөн үйлдвэрийн чиглэлээр 32 төсөл 188.5 сая төгрөг, шинэ 24 хадгалсан 18 ажлын байр, хүнсний үйлдвэрлэлийн чиглэлээр 29 төсөл 233.2 сая төгрөг шинэ 43 хадгалсан 40 ажлын байр, худалдаа үйлчилгээний чиглэлээр 15 төсөл 82.5 сая төгрөг шинэ 16 хадгалсан 14 ажлын байр, мал аж ахуйг хөгжүүлэх чиглэлээр 27 төсөл 162.0 сая төгрөг шинэ 30 хадгалсан 33 ажлын байр, газар тариалангийн чиглэлээр 14 төсөл 85.3 сая төгрөг шинэ 29 хадгалсан 37 ажлын байр, барилгын чигэллээр 22 төсөл 188.5 сая төгрөг шинэ 30 хадгалсан 17 ажлын байр, бусад чиглэлээр 7 төсөл 73.0 сая төгрөг шинэ 17 хадгалсан 10 ажлын байр бий болсон байна.

2011-2019 оны өссөн дүнгээр авч үзвэл: Сум хөгжүүлэх санд 935 төслийн 4.8 тэр бум төгрөгийн үлдэгдэлтэй байгаагаас 2.5 тэр бум төгрөгийн 477 төсөл хэвийн, 417.1 сая төгрөгийн 94 төсөл хугацаа хэтэрсэн, 1.9 тэр бум төгрөгийн 364 төсөл чанаргүй буюу зээлийн гэрээ дуусан үүнээс 302.5 сая төгрөгийн 70 төсөл нь эвлэрэн жуучлах буюу шүүхийн шатанд, 1.0 тэр бум төгрөгийн 143 төслийн шүүхий шийдвэр гараад байна. Зээлийн зориулалтын дагуу ашиглаагүй хугацаа хэтэрсэн зээлдэгчдэд мэдэгдэл хүргүүлэн ажиллаж байна.Чанаргүй зээлийн эргэн төлөлт 38.6 хувьтай байна.

Батлан даалтын сангийн хүрээнд:

Зээлийн батлан даалтын сангийн улирал бүр тайланг холбогдох мэргэжилтэнд хүргүүлэн ажиллаа. Зах зээл бэлчээрийн удирдлага төслийн батлан даалтанд хамрагдсан 3 иргэн, ААН-н үйл ажиллагаанд хяналт хийж, тайлан хүргүүлсэн. Азийн хөгжлийн банкны санхүүжилттэй Зээлийн батлан даалтын сангийн хөнгөлөлттэй зээлд хамрагдахаар Төрийн банкинд 2 аж ахуйн нэгжийн судалгаа хийгдэж байна.

Азийн хөгжлийн банкнаас хэрэгжүүлж буй эх үүсвэртэй батлан даалтын төсөл нь Төрийн банкаар дамжуулан 2019 онд Тэшиг сумын иргэн Г.Мөнхтөр газар тариалангийн үйл ажиллагаагаа өргөжүүлэх чиглэлээр 100.0 сая төгрөгийн зээл олгосон.

Жижиг, дунд үйлдвэр байгуулах чиглэлээр:

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 75 дугаар тогтоолоор Булган, Орхон сумдын хилийн зааг “Домын дэвсэг”-д 140.4 га газарт үйлдвэрлэлийн бүсийг төлөвлөж, “Техник технологи, инноваци нутагшуулах үйлдвэрлэлийн бүсийн Техник эдийн засгийн үндэслэл боловсруулах” зөвлөн үйлчилгээний ажлыг судалгаа шинжилгээний “SICA” ХХК-аар 95.0 сая төгрөгөөр гүйцэтгүүллээ. ТЭЗҮ боловсруулах явцын ажлын тайланг Булган сумын ЗДТГ-ын хурлын зааланд бизнес эрхлэгчдийн дунд, аймгийн Засаг Даргын зөвлөлийн хуралд танилцуулж, хэлэлцүүлсэн бөгөөд Үндэсний хөгжлийн газраас зохион байгуулсан.

Булган суманд “Бүрэн луу” ХХК нь мал бэлтгэх, мах хадгалах хөргүүртэй зоорийг өөрийн хөрөнгөөр үргэлжүүлэн гүйцэтгэж, 1,2 га талбай бүхий газарт хашаа барьж, цахилгаан татаж тоолуур тавьж, худаг гаргаж, бохирын цооног гаргасан. Үүний зэрэгцээ 8 х 12 харьцаа бүхий барилгын өргөтгөлийг хийж 2020 оны хавар ашиглалтанд өгөхөд бэлэн болсон.

Хутаг-Өндөр сумын Булган Мах маркет махны үйлдвэр нь өдөрт 500 бод, 100 бог мал нядлах, 15,0 тонн мах хөлдөөх хүчин чадалтай юм. Мөн 125 тонн мах сэврээх, 500 тонн мах болон дайвар бүтээгдэхүүн хадгалах агуулахтай, өдөрт 15,0 тонн мах ангилах, савлах цех, 10,0 тонн бүтээгдэхүүн боловсруулах тогоо, тоног төхөөрөмжтэй үйл ажиллагаагаа явуулж байна. Мөн үйлдвэрийн байранд капитал засвар хийж, өргөтгөлийн барилга шинээр барьж, махны үйлдвэрлэлийн үйл ажиллагааг тогтворжуулж, орон нутгийн төдийгүй хил залгаа аймгуудын малчдаас мал худалдан авч эдийн засгийн эргэлтэд оруулан, гадаад дотоодын зах зээлд 450.0 тн мах нөөцлөн нийлүүлж байна.

Энэ онд тус үйлдвэр нь олон улсын эрүүл ахуйн хяналтын тогтоцооны стандарт haccap- ыг нэвтрүүлэх бэлтгэл ажлуудыг үе шаттай хийж, үл тохирлыг арилгаж, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг тогтворжуулах ажлуудыг хийгээд байна.

Булган сумын иргэн Д.Сүхбаатар сум хөгжүүлэх сангаас 15.0 сая төгрөгийн зээл авч ОНӨ хог хаягдлын дахин боловсруулах үйлдвэрийг ажилуулан саван, сүүлний тос, адууны тос гэх бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна.

Хангал сумын Хялганат тосгонд өөрийн хөрөнгө оруулалтаар зөгийн бал савлах үйлдвэр ашиглалтанд орж, Улаанбаатар, Орхон, Булган аймаг руу захиалгын дагуу савлан нийлүүлэлт хийж байна.

Үйлдвэржилт 21:100 хөтөлбөрийн хүрээнд :

"Булган хөгжил" корпораци Турк улсын хөрөнгө оруулалтаар Дашинчилэн суманд мах боловсруулах үйлдвэр байгуулахаар 5 га газрыг зөвшөөрөл авсан.

Булган сумын "Хатан Мээж хайрхан" ХХК нь ЖДҮХС- аас 674.0 сая төгрөгийн зээл авч Сүүний үйлдвэр байгуулахаар хуучин барилга обьектод капитал засвар хийж, үйлдвэрийн дулаан боловсруулалтын цехийг шинээр барьж, цэвэр бохир усны дэд бүтцийг шийдвэрлэж, технологийн уурын болон обьектийн халаалтыг системийг барьж, үйлдвэрийн тоног төхөөрөмжийг бүрэн суурьлуулаад байна.

Хутаг-Өндөр суманд "МДМ" ХХК нь хуурай сүүний үйлдвэрийн тоног төхөөрөмж суурилуулан орон нутгийн 3 хүнийг улирлын чанартай ажлын байраар ханган ажиллаж байна.

Хангал сумын Хялганат тосгонд мод боловсруулах үйлдвэр байгуулахаар" Бэлсэг" ХХК тоног төхөөрөмж судлаж хөрөнгийн эх үүсвэр хайж байна.

“Шинэ хөдөө – Булган” төслийн хөрөнгө оруулалтаар :

2019 онд нийт 15 иргэнийг үйлдвэрийн сургалтанд хамруулан сертификат олгож, 15 суманд нэг ээлжиндээ 25-аас дээш арьс боловсруулах хүчин чадал бүхий арьс, нэхий элдэх иж бүрэн төхөөрөмж, нийлүүлэн суурилуулаа.

Хутаг-Өндөр, Сайхан, Хангал, Сэлэнгэ, Орхон, Дашинчилэн, Бугат сумдад 20 фит-ын контейнерт суурилагдсан 3 тн сүү агуулах хүчин чадалтай шинжилгээний багаж бүхий сүүний хөргөлтийн танк тус бүр 1-ийг, Сайхан суманд айраг хадгалах 40 тн-ын хөргүүрт чингэлгийг хүлээлгэн өглөө. Контейнерийг сумдад суурилуулан, 2020 оны хавар ажиллуулах зааварчилгаа туршилтыг хийхээр тохиролцов.

Улсын хэвтээ болон босоо тэнхэлгийн зам дагуу борлуулалтын цэг байгуулах ажлыг эхлүүлээд байна.

“Нэг суурин-Нэг бахархал аян”-ны хүрээнд :

ХХААХҮЯ-наас “Нэг суурин Нэг бахархал” аянг зохион байгуулах Аймгийн Засаг даргын 2019 оны 04 дүгээр сарын 11-ны А/205 тоот захирамжаар ажлын хэсэг байгуулсан.

“Брэндийг хэрхэн бий болгох” сэдэвт сургалтыг сумын мэргэжилтэн болон жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг хамруулан 100 гаруй хүнийг хамруулан 1.0 сая төгрөгийн зарцуулсан.

Мөн жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн бүтээгдэхүүний шилдэг сав баглаа, боодол, хаяг, шошгын уралдаанд 15 сумын 10 -н нэр төрлийн бүтээгдэхүүн ирсэнээс 1-р байр Хангал сумын Хялганат тосгоны “Сүргийн нуга” ХХК -ны Хялгант Зөгийн бал, 2-р байр

Булган сумын “Буман сүхэс” ХХК-ны Адуу үхэрийн жигнэсэн мах /лаазалсан бүтээгдэхүүн/ шалгарсан.

Мөн Орхон, Хишиг-Өндөр, Баян-агт, Хутаг-Өндөр, Хангал сумын брэнд бүтээгдэхүүний хаяг, шошгонд зөвлөгөө мэдээлэл өгөх, үйлдвэрлэж буй бүтээгдэхүүнийг борлуулалтын нэгдсэн цэгтэй холбож өгөх, орон нутгийн худалдан авалтыг дэмжих зорилгоор каталоги гаргахаар 1.5 сая төгрөгийн хөрөнгө зарцуулан ажиллаж байна. Стандарт хэмжилзүйн хэлтэстэй хамтран сумдад стандарт хаяг шошгийн талаар зөвлөгөө мэдээлэл гарын авлага өгч ажиллаа.

Германы ОУ-ын хамтын ажиллагааны нийгэмлэгийн "ЭТИС" хөтөлбөр жижиг, дунд үйлдвэрлэл үйлчилгээг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор манай аймагт хэрэгжиж эхэллээ. Тус хөтөлбөр нь жижиг, дунд үйлдвэрлэл, аялал жуулчлал, газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдийг чадавхижуулах сургалт, инновацийн төсөлд буцалгүй дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэнэ. "Маркетинг, брэндинг, борлуулалт"-ын 3 хоногийн сургалтад 30 үйлдвэрлэгчээ сургаж чадавхижууллаа.

Монгол улсад атар газар эзэмшсэний 60 жилийн хүрээнд “Эрүүл хүнс-Эрүүл монгол” хүн уриан дор орон нутгийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн бүтээгдэхүүн үйлчилгээний борлуулалтыг дэмжиж, шинэ зах зээл, шинэ түншлэлийг хөгжүүлэх, хүн амыг эрүүл аюулгүй, экологийн цэвэр бүтээгдэхүүнээр хангах зорилгоор “Намрын ногоон өдрүүд-булганд үйлдвэрлэв 2019” үзэсгэлэн худалдааг Булган суманд 2019 оны 10 дугаар сарын 09-11-ний өдрүүдэд Ханжаргалант худалдааны төвд амжилттай зохион байгууллаа.

Тус арга хэмжээнд 12 сумын 50 гаруй иргэн аж ахуйн нэгж, 273 нэр төрлийн бүтээгдэхүүнээр оролцож 30.0-аад сая төгрөгийн борлуулалт хийсэн байна. Орон нутгийнхаа үйлдвэрлэлийн өрсөлдөх чадварыг сайжруулах, хүнсний салбарт эрүүл, шударга өрсөлдөөнийг өрнүүлэх, харилцан туршлага судлах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор үзэсгэлэн худалдааны шилдэг бүтээгдэхүүний шалгаруулалтыг 14 төрлийн номинациар шалгаруулж, орон нутгийн брэнд үйлдвэрлэгчдээ шагнаж урамшууллаа.

Булган сумын иргэн Д.Батцэцэг нь өөрийн санхүүжилтээр “Булган үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн” борлуулалтыг дэмжин дэлгүүр нээн ажиллаж байна. “Нэг суурин – Нэг бахархал аян”ы хүрээнд орон нутгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч нартай хамтран ажиллах санал тавьж, бүтээгдэхүүнийг холбон ажиллаж байна.

Хөнгөн үйлдвэрийг хөгжүүлэх дэмжих хүрээнд:

Баян-агт, Дашинчилэн, Булган сумд сум хөгжүүлэх сангаас арьс шир боловсруулах, нэхий элдэх тоног төхөөрөмж авахад дэмжлэг үзүүлснээр үйл ажиллагаа явуулж байна.

Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сангаас арьс шир боловсруулах чиглэлээр 1 төсөлд 20.0 сая төгрөг, тавилга үйлдвэрлэлийн чиглэлээр 1 төсөлд 50.0 сая төгрөг, хэвлэлийн чиглэлээр 1 төсөлд 45.0 сая төгрөг, гутал үйлдвэрлэлийн чиглэлээр 2 төсөлд 80.0 сая төгрөг,барилгын тоног төхөөрөмж, бетон хийц хийх чиглэлээр 2 төсөлд 175.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлсэн байна.

Булган сумын иргэн сүхбаатар сум хөгжүүлэх сангаас 15.0 сая төгрөгийн зээл авч ОНӨ хог хаягдлын дахин боловсруулах үйлдвэрийг ажилуулан саван, сүүлний тос, адууны тос гэх бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна.

Хөнгөн, хүнсний аж үйлдвэрийн салбарын 85 жилийн ойг тэмдэглэн тус салбарт ажиллаж байсан болон ажиллаж байгаа 30 гаруй ажилчдын шагналын материалыг хүргүүлэн эхний ээлжинд 31 шагнал эзэнд нь гардуулаад байна. тэргүүний хоршоологч 2, ххаахүя-ны жуух бичиг 4, хөдөө аж ахуйн худалдаа үйлдвэрийн тэргүүнээр 1, худалдаа үйлдвэрийн тэргүүний ажилтан тэмдэгээр 24 тус тус шагнагдсан байна.

Ойн арилчилгаа огтолцол төслийн хүрээнд Орхон, Бугат, Хангал, Сэлэнгэ сумдад 500 гаад ойн арчилгаа хийлгэх ажлыг зохион байгуулж 72.8 сая төгрөгийг зарцуулсан. Байгаль орчны салбарын нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж 4 хүнийг аймгийн Засаг даргын жуух бичиг, Аймгийн тэргүүний ажилтан тэмдгээр шагнаж урамшуулсан. Экологид ээлтэй бүтээгдэхүүн 2019 үзэсгэлэн худалдаанд Бугат, Орхон, Хутаг-өндөр, Тэшиг, Сайхан, Хангал, Сэлэнгэ сумдын 27 нөхөрлөлийн бүтээгдэхүүнийг оролцуулан 10 гарй сая төгрөгийн борлуулалт хийж, шагналт байр эзэлсэн байна.

Ахуйн үйлчилгээний чиглэлээр:

ХХААХҮЯ-ны холбогдох мэргэжилтэнтэй хамтран ажиллаж Ахуйн үйлчилгээний салбарыг хөгжүүлэх хөтөлбөр болосвруулах ажлын хүрээнд судалгаа, хэлэлцүүлэг хийж хүргүүлсэн.

Явуулын ахуйн үйлчилгээг “Тэнгэрийн түмний хийморь”ХХК нь Баяннуур, Дашинчилэн, Гурванбулаг, Могод, Хишиг-Өндөр, Орхон, Бүрэгхангай зэрэг сумдуудад хүүхдийн дүрэмт хувцас, ажлын хувцас, аранз, ноос, ноолууран хувцасны 2.0 сая төгрөгийн борлуулалт хийж, захилга авч газар дээр нь нийлүүлэн ажиллаа.

Хоршооны чиглэлээр

Хөдөө аж ахуйн хоршоологчдын улсын зөвлөгөөнд 13 хүн, "Тогтвортой хөгжил залуу хоршоологчдын оролцоо сэдэвт сургалтанд 5 хоршооны гишүүн, “Шинэ хөдөө” төслийн хүрээнд “Үндэсний нэхээс хоршоо”, “Сэрж өндөр хоршоо”-ны 3 гишүүнийг сургалтанд

хамруулж, арсь нэхий боловсруулах иж бүрэн тоног төхөөрөмж хөнгөлөлттэй нөхцөлөөр олголоо.

“Баянбайгаль” хоршоо нь хөнгөлөлттэй нөхцлөөр шинэ хөдөө төслөөс 1400 ш чацарганы суулгац авч 1.5 гаад тариалан энэ жил 1 тн жимс хураан авсан амжилттай байна.

Хөнгөн аж үйлдвэрийн 85 ойн хүрээнд Хангал сумын Хялганат тосгоны “Эко хялганат” хоршооны захирал Б.Даариймаа, Могод сумын “Тариат догз” хоршооны захирал Ц.Дулмаа нар Тэргүүний хоршоологч тэмдэгээр шагнагдсан байна.

Дутагдалтай талууд:

- “Жимс, жимсгэнэ”, “Чацаргана” хөтөлбөрийг эрчимжүүлэх, Гурванбулаг, Бүрэгхангай, Хишиг-Өндөр зэрэг зарим сумдын үүрэг, оролцоо, хариуцлагыг нэмэгдүүлж ажиллах шаардлагатай.
- Сум бүр өөрийн хүн амын төмс, хүнсний ногоо, жимс жимсгэний хэрэгцээнд үндэслэн тариалалтын хэмжээг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлого, арга хэмжээг авч хэрэгжүүлэх ажил хангалтгүй байгаагаас төмс, хүнсний ногооны тариалалт нэмэгдэхгүй буурч байна.
- Сумдаас ирж байгаа тайлан, мэдээний чанар, хугацаанд анхаарч ажиллах, ялангуяа Улс, аймгийн сайн малчид, тариаланчдыг шалгаруулах материалууд жилийн жилд шаардлагатай хугацаандаа, баримт бичгийн бүрдэл нь гүйцэт ирдэггүй.
- “Чацаргана” төслийг хангалтгүй хэрэгжүүлсэн сумдууд бүл, өрх, иргэдээ шинэ зохион байгуулалтанд оруулж тариалах сонирхолгүй иргэдийг хасах, шинээр тарих иргэдэд газрыг нь шилжүүлэх.
- Төсөлд зарцуулсан хөрөнгө оруулалтыг нэгдсэн удирдлага, бүртгэлтэй болгож эзэнжүүлэх, эргэн төлөгдөх нөхцлийг тодорхойлж, гэрээ хийж баталгаажуулах.
- Сум хөгжүүлэх сангийн хяналтын зөвлөл зээлийн зориулалт, эргэн төлөлтөнд хяналт тавьдаггүй улмаас чанаргүй зээлийн хувь буурахгүй байна.
- Сум хөгжүүлэх сангийн зээлийг олгохдоо шинээр ажлын байр нэмэгдүүлэхэд анхаарах, ихэнхи сумд өргөжүүлэх чиглэлээр зээл олгосноос ажлын байр нэмэгдэхгүй, зээлийн чанар үр ашиг харагдахгүй байна. Мөн хүссэн санхүүжилтийг 40-50 хувиар хасах, хэт жижиглэн өгснөөс иргэн хүссэн үйлдвэрлэлээ явуулах боломж бүрдэхгүй, авсан зээлээрээ үйл ажиллагаагаа эхлүүлдэг боловч нэр төдий ажил болдог тохиолдол их байна.

Цаашид анхаарах асуудал:

- Нийт мал сүргийн тоо толгойг 3.3 саяд барьж, бэлчээр хамгаалахад анхаарч ажиллах
- Бэлчээрийн талхлалтыг сааруулах, гол горхи, булаг шандны урсацыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах, хөрөнгийг жил бүр төсөвт тусгах
- Хадлангийн газрын эзэмшил ашиглалтыг сайжруулах, услах, бордох, хаших замаар ургацыг нэмэгдүүлэх, таримал тэжээл бий болгох ажлыг эрчимжүүлэх;

- Төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний тариалалтыг тогтвортой нэмэгдүүлэх
- Сум бүр өөрийн хүн амын төмс, хүнсний ногоо, жимс жимсгэний хэрэгцээнд үндэслэн тариалалтын хэмжээг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлого арга хэмжээг авч хэрэгжүүлэх
- Өрхийн тариалан эрхлэгчдийг хоршоо, бүлгийн зохион байгуулалтанд оруулж, техник, дундын үйлчилгээгээр хангах арга хэмжээг эрчимжүүлэх
- Усалгаатай тариалангийн хэмжээг нэмэгдүүлэхийн тулд ашиглалтгүй байгаа услалтын системүүдийг ашиглалтанд оруулахад хамтарч ажиллах
- Орон нутгийн малчдад чиглэсэн цогц сургалтын хөтөлбөр боловсруулан зохион байгуулахад анхаарч ажиллах /тэжээл бэлтгэл, бэлчээрийн менежмент, малын эрүүл мэнд хамгаалах, хоршоо бүлгээр ажиллах гэх мэт/
- Төрийн болон Төрийн бус, ОУ-ын байгууллагын хамтын ажиллагааг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах, хөрөнгө оруулалтыг татах
- Сумдад үйлчилгээний төв байгуулах, төв байгуулах, барилгыг заварлах санхүүжилтийг сумын ЗД нар төсөвтэй тусгах
- ЖДҮДС, Сум хөгжүүлэх сангийн зээлийн зориулалт, чанар, эргэн төлөлтөнд хяналт тавих, чанаргүй зээлийг бууруулах
- Хоршоог дэмжих, идэвхижүүлэх чиглэлээр бодитой хөрөнгө оруулалт, аян зохион байгуулах

Хүнс, хөдөө аж ахуйн газар.